



## НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗАР ОНӨААТҮГ ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 04 сарын 10 өдөр

Дугаар A/24

Улаанбаатар хот

Г Унэлгээний хороо байгуулж,  
тушаал хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйл, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10, Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/320 дугаар захирамж, "Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар" ОНӨААТҮГ-ын дурмийн 6 дугаар зүйлийн 6.11 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Засаг даргын 2023 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн А/320 дугаар захирамжийн хавсралтаар батлагдсан Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2023 онд санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг зохион байгуулах Унэлгээний хорооны бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, холбогдох журам, шийдвэрийг мөрдөн ажиллаж, үр дүнг тайлагнахыг Унэлгээний хорооны дарга (Х.Энхбаясгалан)-д даалгасугай.


3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ерөнхий инженер (Т.Оргил-Эрдэнэ)-т даалгасугай.

4. Төсөл арга хэмжээний ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулалттай холбоотой бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлэн холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөхийг Унэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Д.Пүрэвжав)-д үүрэг болгосугай.

5. Энэ тушаал гарсантай холбогдуулан "Унэлгээний хороо байгуулах тухай" Газрын даргын 2023 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн А/19 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Б.МОНХБАТ





Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын  
даргын 2023 оны 04 дүгээр сарын 10.-ны  
өдрийн A/24 дүгээр тушаалын хавсралт

## ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

ДАРГА:

Х.ЭНХБАЯСГАЛАН

(НХОГ-ын Зураг төслийн  
хэлтсийн Зураг төслийн  
хяналтын инженер)

ГИШҮҮД:

Г.ТЭМҮҮЖИН

(НЗДТГ-ын Хөгжлийн бодлого,  
төлөвлөлтийн хэлтсийн Эрчим  
хүчний бодлого төлөвлөлт  
хариуцсан мэргэжилтэн)

Э.ОРГИЛ

( НХОГ-ын Барилга захиалагчийн  
хэлтсийн Цахилгааны хяналтын  
инженер)

Ч.НЯМДАВАА

(Хан-Уул дүүргийн 2 дугаар  
хорооны иргэн)

НАРИЙН БИЧГИЙН

ДАРГА:

Д.ПҮРЭВЖАВ

(НХОГ-ын Санхүү, аж ахуйн хэлтсийн  
Хөрөнгө оруулалтын санхүүжилт  
хариуцсан Ахлах мэргэжилтэн)